



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 556

Улаанбаатар хот

Авлага данснаас хасах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 181/ШШ2017/00315 дугаартай шийдвэр, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 932 дугаартай магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2017 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 001/ХТ2017/00970 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүүгийн тайланд бүртгэлтэй, “Севиллиа Аудит” ХХК-тай холбоотой, 2013 онд үүссэн, 113,000,000.00 (нэг зуун арван гурван сая) төгрөгийн авлагыг найдваргүйд тооцож данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал Х.Бадамсүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Найдваргүй болсон авлагыг үйлдвэрийн газрын данснаас хасах асуудлыг НББОУСтандарт, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Тогтоолын биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0001307